

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-7

***1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн
газарт чиглэл өгөх тухай/*** 3-7

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 9 дүгээр сарын 25-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Х.Ганхуяг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 35 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Г.Ганбаатар;
Чөлөөтэй: Ж.Батсуурь, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Х.Болормаа, Ж.Ганбаатар, П.Сайнзориг.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Засгийн газарт чиглэл өгөх тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт Г.Нарантуяа, С.Тэгшжаргал нар байлцав.

Байнгын хорооны дарга Х.Ганхуяг тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүдэд тараасан талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Баясгалан, Н.Алтанхуяг, Х.Ганхуяг нар үг хэлж, Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлахтай холбоотой өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир тайлбар хийв.

Х.Ганхуяг: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 4
Бүгд: 18
77.8 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 15 минут үргэлжилж, 29 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 62.1 хувийн ирцтэйгээр 10 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
10 цаг 35 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Х.Ганхуяг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 51.7 хувьтай бүрдсэн тул Төсвийн байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Норовын Алтанхуяг, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Чинбатын Номин, Даваагийн Цогтбаатар хаа байна? Банзрагчийн Түвшин, Баатаржавын Мөнхсоёл, Хүрэлбаатарын Булгантуяа, Ринчиндоржийн Батболд, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Тилеуханы Аубакир, Пүрэвжавын Ганзориг, Чинбатын Номин, Далайн Батбаяр, Жадамбын Баясгалан, Хассуурийн Ганхуяг, Даваахүүгийн Пүрэвдаваа, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын ирцтэй байна.

Хэлэлцэх асуудал “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Хоёулаа ярьчихсан юм аа яах гээд байгаа юм бэ?

“Засгийн газрын чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Хэлж байгаа асуудалтай холбогдуулан Байнгын хорооны гишүүдэд товч мэдээлэл өгье. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг хүлээн авч болно гэж заасны дагуу иргэн Э.Батбаярын гаргасан Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлахтай холбоотой өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг Төсвийн байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулсан.

Уг ажлын хэсгийн санал, дүгнэлт болон ажлын хэсгээс боловсруулсан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг 2026 оны 6 сарын 10-ны өдөр Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн дээрх хуралдаанаар Байнгын хорооны гишүүд ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт

асууж, үг хэлж дууссан бөгөөд дараагийн хуралдаанаар тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэхээр хуралдааныг дуусгасан.

Энэ асуудлыг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд ажлын хэсгээс боловсруулсан тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тэгээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн талаар санал гаргах гишүүн байна уу?

Тийм болно оо болно. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүний микрофоныг өгье.

Ж.Батжаргал: Тийм “Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолын төсөл ч бэлтгэгдээд ороод ирчихсэн. Тэгэхээр хуулиараа орон нутагт эрх нь байж байгаа ийм асуудал. Тэгэхдээ энэ татвар өөрөө онцлогтой татвар. Төсөвт төвлөрөөд яг тэр хэмжээгээрээ орон нутгийн замын сан руугаа шилжээд замын засвар арчлалт, бүтээн байгуулалтын ажил руугаа чиглэгддэг ийм татвар. Тийм учраас бид тодорхой байгууллагуудад эрх мэдэл шилжүүлчхээд тэр дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээнийх нь талаар илүү дутуу юм дуугарах нь бараг илүүц болов уу гэж би ингэж бодоод байгаа юм. Зүгээр хууль ер нь өөрөө анх батлагдаад мэдээж тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд орсон, нэлээдгүй урт хугацааг туулсан байна.

Тэгэхээр энэ Монголын авто тээврийн бодлого, бас зохистой хэрэглээтэй холбоотой энэ төрийн бодлогыг энэ хууль өөрөө хангаж чадаж байгаа болов уу гэдэг асуудал байгаа юм. Тийм учраас тэр Хууль тогтоомжийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Засгийн газар ер нь иж бүрэн үнэлгээ хийх хэрэгтэй болчихоод байгаа юм энд. 5 жил тутамд билүү энэ чинь сүүлд шинэчлэгдээд хэд болсон мэдэхгүй байна. Хууль тогтоомжийг 5 жилд бүтэн хяналт үнэлгээ хийх тухай асуудал бий. Үүнийгээ хийгээд шаардлагатай бол шинэчлэх тухай асуудал байж болох юм болов уу гэсэн ийм л надад санаа байгаад байгаа. Тэрнээс өөр юм байхгүй.

Х.Ганхуяг: Санал хэллээ. Ажлын хэсгийн ахлагч тайлбар хэлэх үү? Аубакир гишүүний микрофоныг өгье.

Т.Аубакир: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Энэ ажлын хэсгийг бол тухайн үед миний бие ахалж байсан 5 гишүүний бүрэлдэхүүнтэй Пүрэвдаваа, Мөнхсоёл, Баясгалан гишүүн бид нар ахалж ажилласан байгаа. Тэгээд дүгнэлт гаргаад энэ үндсэндээ бол Нийслэлийн иргэдийн хурлын хуулийн хүрээнд гаргасан шийдвэр байсан. 92 онд батлагдсан хууль маань тухайн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс авах татварын дээд интервалын тогтоол ч гэсэн хуулийнхаа хүрээнд Нийслэлийн иргэдийн Хурал гаргаад, шийдвэрээ гаргаад аваад явж байгаа татварын асуудал.

Нэгэнт иргэнээс өргөдөл, хүсэлт гарсан учраас Байнгын хороо заавал авч хэлэлцэх ёстой байсан. Авч хэлэлцээд энэ бол Нийслэлийн иргэдийн Хурлын хуулийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэдэг дүгнэлтийг гаргасан. Улсын Их Хурал болон Байнгын хороод хуулийн хүрээнд хийсэн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох эрх байхгүй. Пүрэвдаваа гишүүний гаргасан санал бол тухайн үед тийм ээ хуулийн хүрээнд гаргасан шийдвэр. Гэхдээ тэр болсон хурал маань хуулийн хүрээнд болсон уу, үгүй юу гэдэг

асуудал тавиад Нийслэлийн иргэдийн Хурлын удирдлагууд ирж тайлбараа өгөөд ингээд явсан зүйл.

Тийм учраас энэ дээр өөр тухайн үед ажлын хэсгээс өөр санал бол гараагүй. Ингээд Засгийн газарт чиглэл өгөөд энэ авч байгаа татвар энэ хуулийн хүрээнд байна уу юу гэдэг юм тэр зарцуулалтынх нь хяналт юунд нь хяналт тавиад гэсэн ийм чиглэл өгч байгаа нь зөв гэж үзэж байна. Тийм учраас энэ ажлын хэсэг ажиллаад дүгнэлтээ гаргачихсан ийм ажил байгаа юм шүү.

Х.Ганхуяг: Алтанхуяг гишүүн, Баясгалан гишүүн, нэрийг нэмээдхээрэй. Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Бүгдэд нь энэ өглөөний мэнд хүргэе. Энэ ажлын хэсэгт орж ажилласан тэгээд бид нар тухайн үед Пүрэвдаваа гишүүн бид нар ярьж байсан. Энэ санал авах нэгдүгээрт нийслэл энэ эрхээ хэрэгжүүлэх бүрэн эрхтэй. Гэхдээ санал авсан гэж байгаа. Санал авахдаа бид нар тодорхой хугацааны туршид сайт дээрээ байршуулаад тэгээд оролцсон хүмүүсээс санал авсан гэж байгаа юм. Тэгээд тэр үед асуусан шүү дээ. Хэдэн хүн энэ санал хураалтад орсон юм нийслэлийг төлөөлж? Нийслэлд байгаа тэр 900 мянган тээврийн хэрэгсэлтэй иргэдийг төлөөлж хэдэн хүн орсон юм? Энэ орсон хүмүүсээс яагаад 2-хон хүний саналаар шийдчихсэн байгаа шүү дээ энэ асуудал чинь.

Тэгэхлээр санал асуулга нэртэй юм явуулсан болоод сая гаран иргэнийхээ энэ асуудлыг хоёрхон хүний саналаар шийдэж болох уу гэдэг энэ асуудал дээр нийслэл одоо ч дахиад яг тодорхой хариу өгөөгүй. Энэ чинь иргэдийнхээ кармагаас л хулгай хийж байгаа асуудал байгаа шүү дээ. Нэмж болно оо хуулийн хүрээнд тэд нар эрх мэдлийг хэрэгжүүлж болно. Гэхдээ хуулийн хүрээнд шүү энэ зөвхөн хуулийн хүрээнд байх ёстой. Тэрнээс биш 2-хон хүний саналаар 2 сая орчим иргэнийхээ асуудлыг шийдэж болохгүй. Ажлын хэсэг дээр, Төсвийн байнгын хороон дээр ч гэсэн өмнө нь энэ талаар ярьж байсан. Тэгэхлээр энэ дээр миний хувьд бас л эсрэг саналтай байгаа. Энэ бол 2 хүний саналаар шийдэж болохгүй. Энэ процессын алдаа гарсан гэдэг нь бүүр тодорхой байгаа шүү.

Х.Ганхуяг: Алтанхуяг гишүүний микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Өглөөний мэнд хүргэе. Энэ нөгөө 4 сард ярьсан бил үү бараг? Аа тийм тэгээд хэдүүлээ 30 мянган хүнээ санал баахан өгсний дараагаар Их Хурал дээр ирсэн асуудлыг ингэж шийдэж болохгүй л дээ. Бид нар Засгийн газарт чиглэл өгсөн бичиг гаргаад хаяж болохгүй. Нэгдүгээрт би Баясгалан гишүүдийн санал нэг байгаа юм. Процедурынхаа дагуу хийгээгүй энэ нийслэл.

Хоёрдугаарт хуулийн хүрээнд хийж байгаа нь үнэн. Өөрөөр хэлбэл тэр тоо хэмжээгээ тогтоож болно энэ тэр гэдэг тэр заалтын дагуу хийж байх шиг байгаа юм. Тэгэхдээ энэ хүмүүсийн ахуй амьжиргаа, инфляц, юмны үнийн хөөргөдөл, иргэдийн кармагаас гардаг мөнгө хүнд хэцүү бараг кармад нь мөнгө үлдэхгүй байгаа ийм үед энийг унтаж байсан юм шиг явж байснаа 10 оноос хойш өөрчлөхгүй байж байсныг гэнэтхэн 15 жилийн дараа цочингуутаа 1 нөхөр гарч ирээд 1 нөхөр гэдгийг нь би Нямбаатар хэлж байгаа юм. Тэгээд 3 дахин нэмнэ энэ тэр гэдэг энэ бол түрэмгийлэл шүү дээ түрэмгийлэл. Зүгээр л ард түмэн гэдэг бол юу ч биш гэж үзэж байгаа. Иргэдийн ахуй амьжиргаа гэдэг бол юу ч биш. Би яадаг юм хэдэн төгрөг цуглуулбал болно гэж. Тэгээд тэр цуглуулсан мөнгөөрөө ямар элэнцгээ хийж байгаа юм хэдэн бордюр солихоос өөр юм хийдэггүй юм. Хаана

байгаа юм тэгээд тэр түгжрэл нь буураад байгаа юм? Тэгэхээр ийм байдлаар энэ ард иргэдийнхээ асуудалд Улсын Их Хуралд бид нар оролцож хам хэрэгтэн болж ингэж явмааргүй байна шүү би. Тийм учраас энэ ажлын хэсэг дахиж ажилладаг юм уу, энэ ажлын хэсгийг сольдог юм уу энэ Монгол Улсын Засгийн газар чиглэл өгөөд солиороод байх юм байхгүй. Бид нар тэрийг хүчингүй болгоод тэгээд тэр ард түмнийхээ амьжиргааг хараад наадхаа хуулийнхаа хүрээнд хий. Хийхдээ 3 дахин нэмэгдүүлнэ гэдэг юм байхгүй. Би ийм маш тодорхой саналтай байна шүү дээ. Үгүй ээ хавар шийдчих асуудал шүү дээ. Тэгээд одоо бараг ингээд 10 сард авчирчхаад тэгээд нэг иймэрхүү юм өгдөг маш муу байна. Аубакир дарга жаахан ард иргэдийнхээ талд жаахан ийм юм хумаа зөв хий л дээ та нар. Яагаад ингээд тэнгэрт гараад тасраад суучхав аа? Үгүй ээ хүмүүсийнхээ амьжиргааг ер нь мэдэж байгаа юм уу? Дээгүүр нь болохлоор зүгээр хэдэн зуун сая ямар юм гэвэл их наядаар нь нүүрсээ хувааж идэцгээгээд л энэ улсыг ер нь арай дампууруулж байна. Ингэж болохгүй. Тэгээд тэр нийслэлийн хийсэн алдааг Их Хурал үүрч болохгүй, манай Байнгын хороо үүрч бүүр болохгүй. Би санал хэлж байна шүү гишүүд ээ та нар маань дэмжээд энийг болиод тэгээд хэдүүлээ шийдвэрт арга хэмжээ аваад өгчихье. Нэг, ганц удаа ч гэсэн ард иргэдийнхээ талд, үнэн хэлж байгаа хүмүүсийнхээ талд, ядарч зүдэрч байгаа хүмүүсийнхээ талд ганц удаа шийдвэр гаргаадахъя.

Х.Ганхуяг: Батжаргал гишүүний микрофон өгье. Батжаргал гишүүний микрофон өгье. Энэ яах вэ Алтанхуяг гишүүний ярьж байгаа.

Ж.Батжаргал: Үгүй ээ үгүй энэ ийм юм шат шатын хурлууд нэг нэгнийгээ захирдаг биш хөндлөнгөөрөө тухайн шат шатдаа иргэдийн төлөөлөл байхгүй юу. НИТХ-ын шийдвэрийг Их Хурал хүчингүй болгодог тийм эрх зүйн зохицуулалт байхгүй. Тэгэхээр ерөөсөө явах гарц нь энэ. Засгийн газарт чиглэл өгөөд энэ хууль тогтоомж чинь болж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг юмаа хянаад оруулаад ир л гэдэг зүйл. Их Хурал өөрөө интервалыг нь тогтоогоод өгчихсөн, нутгийн өөрөө удирдах байгууллага интервалынхаа түвшинд асуудлаа шийдчихсэн ийм зүйл. Процессын алдаа элдэв бусын юм байгаа бол наад шийдвэрийг өөрийг нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх асуудал дээр л яригдах ёстой ийм үйл явц байхгүй юу. Тийм учраас яах аргагүй Засгийн газраар нь үүнийг нь судлуулаад тэгээд шийдлийг нь авах нь зөв. Тэрнээс эндээс бид өнөө шийдвэр хүчингүй болгох ямар ч эрх зүйн боломж байхгүй.

Х.Ганхуяг: Энэ бол нутгийн захирах орон нутгийн өөрийн бүрэн эрхийн асуудал байгаа Үндсэн хуулийн зөрчилтэй уул нь манай Байнгын хорооноос ямар нэгэн байдлаар нөлөөлөхөд. Хоёрдугаарт ажлын хэсгийн яг нөгөө ажиллах хугацаа нь ингээд дуусчихсан байгаа. Нөгөө өргөдлийг бид нар 3 сарын дотор шийдвэрлэх ёстой байгаа. Тийм учраас Засгийн газарт хяналт тавиад асуудал байвал танилцуулаад тэр үед нь бид нар харин өөрчлөлт оруулах боломж бий.

Хоёрдугаарт гишүүд маань энэ хуультай холбоотойгоор та нар гишүүд маань бас хууль санаачлах эрх чинь бас байгаа гээд сануулах гэсэн юм. Баярлалаа Батжаргал гишүүн үг хэллээ.

Санал хураалт явуулна. Гишүүдээ санал хураалтад бэлдээрэй. Батбаяр гишүүн, Батболд гишүүн хуруугаа. Мөнхсоёл гишүүн, Энхтүвшин гишүүн байхгүй байна уу тээ?

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Төсвийн байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

77.8 хувиар буюу 14 гишүүн дэмжиж тогтоолын төслийг баталлаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүддээ баярлалаа.

10.50 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР